



ТАЛХ ЧИХЭР ХК

БҮҮЯА ХҮНС 1984 ТАНЫ СОНГОЛТ
ОНООС

ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДААНЫ "ТАЛХ ЧИХЭР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 11 өдөр

Дугаар: 05

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60.1 дэх заалт, 62.1.9, 62.1.13 дахь заалт, 64.1, 64.2, 64.4, 65 дугаар зүйл, 67.1, 71.1, 71.3, 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018.12.14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын зар мэдээг хүргэх" журмын 2 болон 3 дугаар зүйлийн заалт болон 2021.01.27 ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны 45 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан 4 дүгээр бүлэгт заасан заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Талх Чихэр" ХК ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 14:00 цагт компанийн өөрийн байрнаас цахим хэлбэрээр буюу хувьцаа эзэмшигчдийг нэг дор цуглуулахгүй байдлаар хуралдуулсугай.
2. Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр оруулсугай. Үүнд:
 1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
 2. Компанийн 2021 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгох, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсвийг батлах
 4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг хэлэлцэн батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 4 ний өдрөөр тогтоосугай.
4. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг "Санхүүгийн Зохицуулах Хороо", "Хөрөнгийн Бирж"-д мэдэгдэх өдрийг 2022 оны 3 дугаар сарын 14 ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2021 оны 3 дугаар сарын 16 ны өдөр болон 4 дүгээр сарын 01 ний өдрүүдэд байхаар тогтоосугай.
5. Хурал хуралдуулах тухай зарыг 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршуулах, 3 дугаар сарын 16 ны өдөр болон 4 дүгээр сарын 01-ний өдрүүдэд өдөр дутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Дараах бичиг баримтуудыг компани дээр 2021 оны 3 дугаар сарын 25 ны дотор бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай. Үүнд
- 6.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай болон Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар

- 6.2 Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас гарах шийдвэрийн төсөл
- 6.3 Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайлан, 2022 оны бизнес төлөвлөгөө
- 6.4 Хурлын санал хураах хуудас
- 6.5 Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн намтар, 2022 оны төсөв
- 6.6 Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд зориулсан танилцуулга
7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №01-ээр баталсугай.
8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 14:00 цагаар тогтоосугай
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг энэхүү шийдвэрийн Хавсралт №02-оор баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг энэхүү шийдвэрийн Хавсралт №03-аар баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар дэд захирал Б.Бурмаа, нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга И.Өлзийбаяр, тэргүүлэгчдээр хувьцаа эзэмшигч Д.Одонгэрэл, Д.Пүрэвсүрэн нарыг сонгосугай.
12. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

Комиссын дарга:	Б. Тэргэл	/Нягтлан бодогч/
Гишүүд:	Л.Шаарийбуу	/Нягтлан бодогч/
	Б.Түвшинзаяа	/Нягтлан бодогч/
	Д.Чимгээ	/Хувьцаа эзэмшигч/
	М. Ганчимэг	/Нягтлан бодогч/
	Б.Жамьянсүрэн	/Нягтлан бодогч/

13. Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлын зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

Комиссын дарга: А.Наранцацрал / Захиргаа Хүний Нөөцийн Албаны дарга/

Нарийн бичгийн дарга: И.Өлзийбаяр /ТУЗ-ийн н/б/ дарга/

Гишүүд:

Ч.Энхтуяа/ Ерөнхий менежер/
 Л. Баттөр /Маркетингийн албаны дарга/
 Д.Батхуяг /Айти инженер/
 Б.Энхдэлгэр /Маркетингийн ахлах менежер/
 Б.Амаржаргал/Маркетингийн менежер/
 Н. Хулан / Хүний нөөцийн менежер/
 Г. Отгонзул /Хүний нөөцийн менежер/

2. Компанийн Хувьцаа Эзэмшигчдэд танилцуулах хурлын материал, танилцуулгыг тараах, хурлын бэлтгэл ажлыг сайтар зохион байгуулж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын дарга / А.Наранцацрал/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ОЮУНМАА